

10-р сарын мэдээ

Мэдээлэл, сургалт, сурталчилгаа

НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөр, Даян дэлхийн байгаль хамгаалах сангийн дэмжлэгтэй БОНХАЖЯ-тай хамтран хэрэгжүүлсэн "Монгол орны ТХГН-ийн сүлжээг бэхжүүлэх нь" төслийн хүрээнд Орхоны хөндийн БЦГ-т гарсан сайн туршлага, сургамжийг хангайн бүсийн хамгаалалтын захиргаад болон олон улсын ТББ (WCS, WWF) танилцуулж, туршлага солилцлоо.



Уулзалт хэлэлцүүлгээр “Хүрхрээ” бүсэд хэрэгжүүлж буй аялал жуулчлалын менежментийн бодит байдалтай газар дээр нь танилцаж аялал жуулчлал эрхлэгч нутгийн иргэд болон Орхоны хөндийн БЦГ-ын менежментийн зөвлөлийн гишүүд, аймаг, сум орон нутгийн удирдлагуудтай хамтран уулзалт хэлэлцүүлэг хийлээ.



Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний IV чуулган “Тусгай хамгаалалттай газар нутаг-Олон улсын болон Монгол улсын төрийн бодлого” сэдвийн хүрээнд Улаанбаатар хотноо амжилттай болж өндөрлөлөө.



Тус чуулганд хамгаалалтын захиргааны дарга, мэргэжилтэнүүд болон харьяа сумдын орчны бүсийн төлөөллүүд оролцсон юм.

Чуулганы үеэр ТХГН-ын хамгаалалтын захиргаадын хуулийн хэрэгжилт, хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн нарт МХЕГ-ын БОХХ-ийн дарга Д.Цэрэндаш Мэргэжлийн

хяналт шалгалтын стандартын тухай, БОХ-ын улсын ахлах байцаагч Ч.Нямдаваа нар Мэргэжлийн хяналтын байцаагчийн ёс зүй талаар сургалт явуулсан.



"Монгол орны ус намгархаг газрын менежментийг сайжруулах" үндэсний анхдугаар сургалт зохион байгуулагдан туршлага судаллаа. Уг сургалтаар RAMSAR-т орсон 11 газар танилцуулга хийн цаашид авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлын талаар хэлэлцлээ.



Хамгаалалтын захиргаанаас байгаль хамгаалагч нартаа нэгдсэн сургалтыг зохион байгууллаа.

Уг сургалтаар Монгол улсын ТХГНутгийн үндэсний 4-р чуулганаар хэлэлцэн шийдвэрлэсэн асуудал, гарсан санал, зөвлөмжийг танилцуулж, "Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох" төслийн танилцуулгыг хийлээ. Мөн цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан хамгаалалтын захиргаа, сум орон нутгаас бүс нутгуудад авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, түүний үр дүн, "Байгаль хамгаалах сарын аян"-ы хэрэгжилт, үр нөлөөг хэлэлцэн дүгнэлээ.

Сургалтын үеэр БОНХАЖ-ын сайд Н.Батцэрэгийн захидалыг албан хаагчиддаа гардууллаа.



2015 оны 10 дугаар сар 25 өдөр Байгаль орчин ногоон хөгжлийн сайд Н.Батцэрэг Орхоны хөндийн БЦГ-ын хамгаалалтын захиргаанд зочлон ажил байдалтай танилцлаа.

Тус уулзалтанд Өвөрхангай аймгийн БОАЖАлба, Хархорин сумын засаг дарга нар оролцож аймаг, сум, орон нутагт байгаль орчин аялал жуулчлалын чиглэлээр хэрэгжүүлж буй ажил, цаашид авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлаа танилцууллаа.



Хамгаалалтын захиргааны дарга, мэргэжилтнүүд ярилцлага хэлэлцүүлэгийн үеэр ажил байдлаа чиглэл тус бүрээр танилцуулан сайд Н.Батцэрэгийг дараах асуудлуудад анхаарч, дэмжихийг хүсч тодорхой хариу авлаа. Үүнд:

1. Орхон голын эхэнд байх алтны уурхайн компаниудаас үүдэлтэй Орхон гол улаан шавраар урсдаг болсон асуудалд анхаарах.
2. Орхон голын сав газрын захиргаа байршилын хувьд хол/ Архангай аймгийн төвд/ учраас ажил төрлөө уялдуулж ажиллахад хүндрэлтэй байна. Үүнийг анхаарч байршилыг нь Хархоринд төвлөрүүлэх.
3. Хамгаалалтын захиргаа Хүрхрээ бүсэд байгаль хамгаалагчийн мэдээлэл, сурталчилгааны байр хийхээр төлөвлөн иргэн Миеэгомбоос /НҮБ-ын ТХГНСБэхжүүлэх нь төслийн санхүүжилтээр/ худалдаж авахаар гэрээ байгуулсан байрыг улсын хөрөнгөд авах асуудлыг шийдэж өгөх.
4. Орхон гол, Найман нуурт загасны судалгаа хийх санхүүжилт хүсэх.
5. Хархорин, Үүртийн тохойн байгаль хамгаалагчийн хяналтын байруудыг гэрэл цахилгааны шугам, өндөр хүчдэлтэй холбох зардалыг гаргах.
6. ТХГНутагт оршдог багийн төвүүдийн сууршил, төлөвлөлтийн асуудалд хэрхэн хандах.
7. Ирэх 2016 онд газар нутгаа тусгай хамгаалалтанд авсаны 20 жилийн ойн арга хэмжээ тэмдэглэх.
8. Хамгаалалтын захиргааны гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, Турк улсын ижил төстэй албадуудтай хамтарч ажиллах, холбоо тогтооход дэмжлэг үзүүлэх.

Сайд Н.Батцэрэг уулзалт хэлэлцүүлэгийн үеэр байгаль хамгаалах үйлсэд идэвх санаачлагатай ажилласан мэргэжилтэн Ч.Суурьтогтох, Д.Эрдэнэчимэг нарт “Байгаль орчны тэргүүний ажилтан” цол тэмдэг гардууллаа.



Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг бэхжүүлэх нь” төслийн санхүүжилтээр хийгдсэн ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх санамж бүхий 26 ширхэг мэдээллийн самбарыг байгаль хамгаалагчид нутаг дэвсгэртээ байрлууллаа.



Хамгаалалтын захиргааны жолооч С.Мөнхбаяр энэ жил Сумын заан болсонтой холбогдуулан захиргаа, хамт олны зүгээс 5 ханатай өргөө цагаан гэрээр мялаалга өргөлөө.



Байгаль хамгаалал, хяналт шалгалт

Монгол улсын Ерөнхийлөгчийн “ Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 2010 оны 36 дугаар зарлиг, БОНХАЖ-ын сайдын “ Нэг сая мод ургуулах хөдөлгөөн”-ий хүрээнд Өвөрхангай аймгийн Хархорин сум” Хүүхэд залуучуудын цэцэрлэгт хүрээлэн”-д 20 ширхэг бургас, хамгаалалтын захиргааны Эко мэдээллийн төвийн хашаанд 20 ширхэг улиас нийт 40 ширхэг модыг шинээр тарьж, хавар тарисан модооо арчилж цэнэг усалгаа хийлээ.

2015 оны 10-р сарын 16-нд хамгаалалтын захиргааны мэдээллийн төвд Хархорин сумын ТХГН-т байгаа бэлчээр хамгаалах малчдын бүлэг болон Хархорин сумын газрын даамал, байгаль хамгаалагч, хамгаалалтын захиргааны мэргэжилтэн байгаль хамгаалагчдын дунд НҮБХХ-ийн ТХГН-ын сүлжээг бэхжүүлэх нь төслийн санхүүжилтээр “ Бэлчээр хамгаалал ба бэлчээрийн ургац тодорхойлох энгийн аргачлал” сэдэвт сургалтыг Доктор Н.Алтанзул багш удирдан явууллаа. Сургалтанд Орхоны хөндийн ТХГН-т байгуулагдсан малдын 6-н бүлгийн төлөөлөл бүхий нийт 22 хүн оролцсон.



Хамгаалалтын захиргааны даргын баталсан удирдамжийн дагуу хуулийн хэрэгжилт хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн Д.Эрдэнэчимэг Төвхөн хариуцсан байгаль хамгаалагч, байцаагч Ц.Төмөрхуяг Хойд агуйт хариуцсан байгаль хамгаалагч Ш.Нямсүрэн, Хотонт сумын Тэмээ хүзүү хариуцсан байгаль хамгаалагч П.Баянжаргал нар Хужирт сумын Их бага Уньт, Сайрт, Хархорин сумын Шивэрт, Сөрт зэрэг газруудад ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хяналт хийж, иргэдэд мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгууллаа.

Шалгалтаар Хужирт сумын Их уньт, Шивэртэд самар түүх зорилгоор байрласан 9 галын 29 иргэнд Тусгай хамгаалалттай газар нутгийн болон байгаль орчны хууль танилцуулан сурталчилж ажиллаа.

Улсын ТХГНутаг болох Бат-Өлзий сумын Улаан ам багийн төвд иргэн н.Шаарынямбуу нь зохих зөвшөөрөлгүйгээр өрхийн хэрэгцээнд зориулан 9*9 харьцаатай орон сууцны байшингийн суурийг цутгаж, 2 үе тоосгоор туурга өрсөн байсныг улсын байцаагчийн акт үйлдэж үйл ажиллагааг зогсоож, Газрын тухай хуулийг үндэслэн 1920000 төгрөгийн торгууль ногдууллаа.

Мэдээ нэгтгэсэн:Мэргэжилтэн Ч.Суурьтогтох.